



“ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЧИГ ХАНДЛАГА” СЭДЭВТ САРЫН АЯНЫ ТАЙЛАН

2017.12.03

Аймгийн засаг даргын 2017.10.31-ний өдрийн А/619 тоот захирамжаар баталсан “Хүний эрхэд суурилсан чиг хандлага” сэдэвт нэг сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. “Хүний эрхэд суурилсан чиг хандлага” хууль сурталчлах аяны хүрээнд аймгийн Ахмадын хорооны зөвлөх багш Н.Дашлагцэгмаа /Музейн ажилтны ёс зүй, үүрэг хариуцлага, Хүний эрхийн тухай ойлголт, Хүүхдийн эрх/, н.Пагамдулам /Хорт зуршилаас ирээдүйгээ аваръяа/ сэдвээр сургалт хийсэн бөгөөд сургалтаар хүний болон хүүхдийн эрх, үүргийн тухай ойлголт, амьдрал ахуйдаа мөрдөж хэрэгжүүлэх, мөнхүүхэд хойч үеэ цахим болон орчны хорт зуршилд автуулахгүй, сэргийлж байх талаарх мэдээ мэдээллийг авлаа.



2. Хууль сурталчилах ажлын хүрээнд Биеийн тамир спортын газар, Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын сан, Аймгийн музей, Монгол туургатан театр хамтран “Зөрчлийн тухай хууль, Ажлын байран дахь дарамт, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн мэдлэг олгон сурталчилах зорилгоор нийт 45 ажилтан албан хаагчдад сургалт хийлээ.



Энэхүү сургалтыг Төв аймаг дахь хүний эрхийн үндэсний комиссын төв дахь мэргэжилтэн У.Чойжилсүрэнгээр удирдуулан хуулиа судалж мэдэх, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хуулийн онцлох заалтуудын талаарх тодорхой ойлголтыг ажилтан албан хаагчдадаа хүргэж, мэдлэгээ бататган 4 байгууллагынхаа төрийн албан хаагчдын дунд АХА-тэмцээнийг зохион явуулахад:

1-р байрыг Биеийн тамир спортын газрын бичиг хэргийн ажилтан Д.Энхцэцэг

2-р байрыг Музейн ЭША- Ц.Цэцэгжаргал нар эзэлж дурсгалын зүйлээр шагнагдлаа.

3. “Хүүхдийн эрх” сэдвээр Монгени 5-р сургуулийн 4в ангийн 25 сурагчдад хүний эрх болон хүүхдийн эрхийн тухай, эрхээ хаанаас мэдэж болох, хүүхдийн эрхийг хэзээ баталсан хэзээнээс хэрэгжүүлсэн, хүүхдийн эрх болон үүргээ биелүүлэх, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага хүүхдийн эрхийг зөрчигдөд хуулийн ямар хариуцлага хүлээлгэдэг талаарх мэдээлэл өгч, ярилцлага зохион байгуулсан.

4. Музейгээр үйлчлүүлсэн иргэд болон дээрх сургалтад хамрагдсан 4 байгууллагын албан хаагчид, сурагчдад хүний эрхийн талаарх гарын авлагыг хувиалан нийт 73 ширхэгийг тарааж сурталчилсан байна.



Тайлан бичсэн: Музейн ЭША Ц.Цэцэгжаргал